



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/569

Эрдэнэт


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.2, Ахмад настны тухай хуулийн 13.4 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 09 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ач санах дэд хөтөлбөрийн хүрээнд Их залуу багийн иргэн ахмад настан Б.Бадамрагчаагийн хувиараа эрхлэж буй цагаан идээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 200000 төгрөгийн, 2018 оны 09 дүгээр сарын 27,28-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Софт воллейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгаа төлөөлөн оролцох ахмад мастеруудын баг тамирчдад 500000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 700000 /Долоон зуун мянган/ төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын "Ач санах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ